# ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ ТАРХАЛТЫН МЭДЭЭ

Хоёр долоо хоног тутмын мэдээ **№2**

**НЭГ. Шувууны томуугийн А хүрээний вирусын шувууны өвчлөлийн хураангуй мэдээлэл:**

2022 оны 01-р сарын 07 ноос 01-р сарын 21 ний хооронд шувууны томуугийн А хүрээний вирус БНХАУ, Нигер, Вьетнам, Дани, Португал, Испани, Өмнөд Солонгос, Япон, АНУ, Хорват зэрэг улс орны газар нутагт хүний болон нүүдлийн, тэжээвэр шувуудын дунд бүртгэгдсэн (Дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгт 1, зураг 1 ээс харна уу).

**ХОЁР. Шувууны томуугийн А хүрээний (H5N1) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:**

2022 оны 01-р сарын 07 ноос 01-р сарын 21 ний хооронд шувууны томуугийн А хүрээний H5N1 вирусын хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй байна.

**ГУРАВ. Шувууны томуугийн А хүрээний (H5N6) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:**

2022 оны 01-р сарын 07 ноос 01-р сарын 21 ний хооронд шувууны томуугийн А хүрээний H5N6 вирусын хүний өвчлөлийн нийт 6 тохиолдол бүртгэгдсэн.
Бүх 6 өвчтөнд 2021 оны 12-р сард өвчний шинж тэмдэг илэрсэн. БНХАУ-н Хойчжоу, Лючжоу, Ханжоу, Лэшань хотын 28-75 насны иргэд өртсөн ба үүнээс 2 эрэгтэй нь нас барж, бусад өвчтөнүүдийн биеийн байдал хүнд байна гэж Хонконгийн Эрүүл мэндийг хамгаалах төвөөс мэдээлсэн. Нэг иргэнээс бусад нь шинж тэмдэг илрэхээс өмнө үхсэн шувууны аж ахуйд (шувууд нь өвчилсөн, үхсэн) ажиллаж байсан.

**ДӨРӨВ. Шувууны томуугийн А хүрээний (H7N9) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:**

2022 оны 01-р сарын 07 ноос 01-р сарын 21 ний хооронд шувууны томуугийн А хүрээний H7N9 вирусын хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй байна.

**ТАВ. Шувууны томуугийн А хүрээний (H9N2) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:**

2022 оны 01-р сарын 07 ноос 01-р сарын 21 ний хооронд шувууны томуугийн А хүрээний H9N2 вирусын хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй байна.
БНХАУ-н Гуандон аймгийн Хэюань хотын 7 настай эрэгтэй хүүхдэд 11-р сарын 28 нд өвчний шинж илэрч эмнэлэгт хандсан. Шинж тэмдэг илрэхээс өмнө шувууны аж ахуйд ойр амьдарч байсан. Өвчтний биеийн байдал одоогоор хөнгөн байна.

**ЗУРГАА. Шувууны томуугийн А хүрээний (H7N4) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:**

2022 оны 01-р сарын 07 ноос 01-р сарын 21 ний хооронд шувууны томуугийн А хүрээний (H7N4) вирусын хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй.

**ДОЛОО. Шувууны томуугийн А хүрээний (H5N8) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:**

2022 оны 01-р сарын 07 ноос 01-р сарын 21 ний хооронд шувууны томуугийн А хүрээний (H5N8) вирусын хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй.

**НАЙМ. Шувууны томуугийн А хүрээний (H10N3) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:**

Мөн хугацаанд шувууны томуугийн А хүрээний (H10N3) вирусын хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй.

**ЕС. 2022 оны 01-р сарын 07 ноос 01-р сарын 21 ний хооронд шувууны томуугийн А хүрээний вирусээр өвчилсөн хүний болон шувууны мэдээлэл (Хүснэгт 1):**

(Хүснэгт 1) Шувууны томуугийн А хүрээний вирусын тархалт болон вирусын хэлбэр

| № | Мэдээлсэн өдөр | Өвчилж эхэлсэн өдөр | Дэд хэвшинж | Улс | Муж, газрын нэр | Өртсөн нийт хүн, шувуудын тоо | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 1/6/2022 | 1/7/2022 | H5N6 | БНХАУ | Хойчжоу | 1 | 43 настай эмэгтэй |
| 2 | 1/10/2022 | 11/28/2021 | H9N2 | БНХАУ | Хэюань хот | 1 | 7 настай эрэгтэй |
| 3 | 1/7/2022 | 12/31/2021 | H5N1 | Нигер | Ниамéй | 18575 | Тахиа |
| 4 | 1/7/2022 | 12/28/2021 | H5N1 | Вьетнам | Хай Тонг | 18144 | Тахиа |
| 5 | 1/7/2022 | 12/13/2021 | H5N8 | Дани | Хольстебро | 1 | Гангар хун |
| 6 | 1/7/2022 | 12/30/2021 | H5N1 | Португал | Алпиарса | 100 | Нүүдлийн |
| 7 | 1/8/2022 | 12/30/2021 | H5N1 | Испани | Льейда | 4 | Хун, өрөвтас |
| 8 | 1/13/2022 | 12/1/2022 | H5N6 | БНХАУ | Лучжоу хот | 1 | 75 настай эрэгтэй |
| 9 | 1/13/2022 | 12/8/2022 | H5N6 | БНХАУ | Лэшань хот | 1 | 54 настай эрэгтэй |
| 10 | 1/13/2022 | 12/15/2022 | H5N6 | БНХАУ | Ханжоу хот | 1 | 51 настай эмэгтэй |
| 11 | 1/13/2022 | 12/19/2022 | H5N6 | БНХАУ | Лючжоу хот | 1 | 53 настай эрэгтэй |
| 12 | 1/13/2022 | 12/23/2022 | H5N6 | БНХАУ | Лючжоу хот | 1 | 28 настай эрэгтэй |
| 13 | 1/16/2022 | 1/6/2022 | H5N1 | Өмнөд Солонгос | Ён-Ам хошуу | 83,663 | Нугасны аж ахуй |
| 14 | 1/16/2022 | 1/6/2022 | H5N1 | Япон | Эхимэ | 130,000 | Тахианы аж ахуй |
| 15 | 1/19/2022 | 1/10/2022 | H5N1 | АНУ | Коллетон | 1 | Нугас |
| 16 | 1/19/2022 | 1/12/2022 | H5N1 | АНУ | Хайд | 1 | Халбага нугас |
| 17 | 1/18/2022 | 1/13/2022 | H5N1 | Испани | Канталехо | 18,900 | Цацагт хяруул |
| 18 | 1/17/2022 | 1/10/2022 | H5N1 | Хорват | Бели манастир | 52 | 43 зүйл шувууд |

Эх сурвалж: *www.poultrymed.com, Cidrap.umn.edu*

(Зураг 1) 2022 оны 01-р сарын 07 ноос  01-р сарын 21 ний хооронд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусын тохиолдлын тархалт, Монгол орныг дайран өнгөрөх нүүдлийн шувуудын томоохон замууд /зургаар/




**АРАВ. Монгол оронд бүртгэгдсэн шувууны томуугийн сэжигтэй тохиолдолын мэдээлэл:**

2022 оны 01-р сарын 07 ноос 01-р сарын 21 ний хооронд шувууны томуугийн холбогдолтой өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдээгүй байна.